

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН АЛБАН ДААЛГАВАР

20~~18~~ оны 09 дугаар сарын
02-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ажлын хариуцлага, сахилга бат, дэг журмыг чангатгаж,
ажлын чанар үр дүнг дээшлүүлэх тухай

“Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн аудитын бүх шатны байгууллагуудад албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга бат, дэг журмыг чангатгах зорилгоор Монгол Улсын Ерөнхий аудитор Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7-д заасан бүрэн эрхийнхээ дагуу дараах албан даалгаврыг өгч байна. Үүнд.

Нэг. Ерөнхий аудиторын орлогч, УАГ-ын Тамгын газрын дарга, төрөлжсөн аудитын болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, захирал бөгөөд тэргүүлэх аудитор, хэлтэс, албадын дарга нарт:

- 1.1. Төрийн аудитын байгууллагын нийт албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлж, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах;
- 1.2. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн аудитын байгууллагын албан тушаалыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандaa тууштай тэмцэж, авлигагүй, шударга ёс зүйтэй орчинг бүрдүүлэх;
- 1.3. Төрийн аудитын байгууллагад иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, хуульд засан хугацаанд асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хуулийн хугацаанд хариуцлага тооцож, дахин зөрчил, дутагдал гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч байх;
- 1.4. Төрийн дээд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ олон нийтэд ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг баримтлан хүнд суртал, чирэгдэлгүй, ёс зүйн догондол гаргахгүй байх;

1.5. Бүх шатанд ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэн, ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлж, ажлын байранд дараах дэг журмыг тогтоож мөрдөн ажиллах; Үүнд:

а/. Ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хадгалах, хэрэглэх, худалдах, үйлчлэх, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ албан үүрэг гүйцэтгэхийг хориглох;

б/. Согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн иргэнд үйлчлэх, ажлын байранд нэвтрүүлэх, албан томилолтоор ажиллах үедээ согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох;

в/. 1.5-ын а, б-д заасан дэг журмыг зөрчсөн албан хаагчдыг албан тушаалаас нь шууд чөлөөлөх;

г/. Ажлын байр, түүний орчимд тамхи татах, худалдах, үйлчлэх;

д/. Ажлын байранд Төрийн аудитын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 13 дугаар зүйлд заасан дотоод ажлын хяналт, хариуцлагыг хэрэгжүүлж биелэлтэд нь хяналт тавин үр дүнг тооцож ажиллах;

1.6. Төрийн аудитын бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн аудитын байгууллагын албан хаагчдыг тогтвэр суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх талаар тодорхой бодлого боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

1.7. Албан тушаалтны ажлын хариуцлага, сахилга батыг өндөржүүлж, төлөвлөгөөт болон завсарын аудитыг цаг алдалгүй чанартай хийж, аудитын явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, Төрийн аудитын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Төрийн албаны тухай хууль, төрийн албаны стандартыг мөрдүүлж ажиллах;

1.8. Санхүүгийн сахилга батыг бэхжүүлж, Монгол Улсын Ерөнхий аудитороос шилжүүлсэн эрхийн хүрээнд төсвийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллах;

1.9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, хууль тогтоомжид заасан ажлыг нийтэд ил тод, нээлттэй болгон шударгаар зохион байгуулж, үр дүнг дүгнэж ажиллах;

1.10. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа чанаргүй гүйцэтгэсэн, ажилдаа хариуцлагагүй хандсан, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр хуулийн хугацаанд хариуцлага тооцож байх;

1.11. Ажилтнуудын үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнг урамшуулал, ажлын хариуцлагатай холбож ажиллах;

1.12. Архивын тухай хууль болон архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг чанд мөрдөж, архив, албан хэрэг хөтлөлтэй холбоотой мэдээ, тайланг хуулийн хугацаанд нь үнэн зөв гаргаж байх;

2. Албан даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсээр дүгнэж, тайлангаа ирүүлэхийг Үндэсний аудитын газрын Тамгын дарга, төрөлжсөн болон аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, захирал, тэргүүлэх аудитор, хэлтэс албадын дарга нарт үүрэг болгож байна.

3. Энэхүү албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн, тайланг танилцуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга /Ц.Ганболд/-д хариуцуулж байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР

